


КОВИД-19 халдварт цар тахлаар өвчилсөн иргэдийн 42.6 хувь нь аль нэг төрлийн вакцинд хамрагдсан байжээ.

2021 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Монгол Улсын 12, түүнээс дээш насны хүн амын 84.6 хувь нь бүрэн тунд хамрагдсанаас 69.5 хувь буюу 10 хүн тутмын 7 нь БНХАУ-ын VeroCell вакцин хийлгэсэн байна (Зураг 1).


Зураг 1. КОВИД-19 халдварын эсрэг вакцинд хамрагдалт, төрлөөр, дүнд эзлэх хувиар



Эх үүсвэр: Халдварт өвчин судлалын үндэсний төв, Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв.

КОВИД-19 халдварын батлагдсан тохиолдлын 42.6 хувь нь КОВИД-19-ийн эсрэг аль нэг төрлийн вакцины нэгдүгээр болон бүрэн тунд хамрагдсаны дараа өвчилсөн байна. Тодруулбал, өвчилсөн иргэдийн 13.1 хувь нь нэгдүгээр тунд хамрагдсаны дараа, 29.5 хувь нь бүрэн тунд хамрагдсаны дараа өвчилсөн байна. Харин өвчилсөн иргэдийн 57.4 хувь нь огт вакцинд хамрагдаагүй иргэд байна (Зураг 2).


Зураг 2. КОВИД-19 халдварын батлагдсан тохиолдлын бүтэц, вакцинд хамрагдсан байдлаар, дүнд эзлэх хувиар



Эх сурвалж: Халдварт өвчин судлалын үндэсний төв, Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв

Covishield (БНЭУ) вакцины бүрэн тунд хамрагдсан иргэдийн 8.7 хувь нь COVID-19 халдвараар өвчилсөн нь бусад вакцинтай харьцуулахад хамгийн өндөр байна. Харин манай улсын хүн амын ихэнх хувь нь БНХАУ-ын VeroCell вакцинд хамрагдсан бөгөөд эдгээр иргэдийн 2.6 хувь нь бүрэн тунд хамрагдсаны дараа өвчилсөн байна (Зураг 3).


Зураг 3. COVID-19 халдварын эсрэг бүрэн тунд хамрагдсан, өвчилсөн иргэдийн эзлэх хувь, вакцины төрлөөр



Эх үүсвэр: Халдварт өвчин судлалын үндэсний төв, Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв

COVID-19 халдварын эсрэг вакцины бүрэн тунд хамрагдсанаас хойш өвчилсөн иргэдийг вакцинд хамрагдсан өдрөөс хойш халдвар авсан хоногоор авч үзэхэд 31 ба түүнээс дээш хоногийн дараа өвчилсөн иргэд дийлэнх хувийг эзэлж байна. Тодруулбал, AstraZeneca вакцины бүрэн тунд хамрагдсанаас хойш 31 ба түүнээс дээш хоногийн дараа өвчилсөн иргэд хамгийн өндөр буюу 81.7 хувийг эзэлж байгаа бол Covishield - 80.8 хувь, Спутник - 71.4 хувь байна. VeroCell вакцинд хамрагдсаны дараа халдвар авсан иргэдийн 15.9 хувь нь 14 хүртэлх хоногт, 16.9 хувь нь 15-30 хоногийн дотор өвчилсөн байна. Pfizer вакцинд хамрагдсаны дараа халдвар авсан иргэдийн 36.7 хувь нь 14 хоногийн дотор өвчилсөн байна (Зураг 4).

Зураг 4. COVID-19-ийн эсрэг бүрэн тунд вакцинд хамрагдаад өвчилсөн иргэд, вакцины төрөл, хамрагдсанаас хойш өвчилсөн хоног, дүнд эзлэх хувиар.




Эх үүсвэр: Халдварт өвчин судлалын үндэсний төв, Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв

12-24 нас болон 70-аас дээш насныхны талаас илүү хувь нь дархлаажуулалтын бүрэн тунд хамрагдсанаас хойш 45 хоногийн дотор халдвар авсан бол 25-69 насны иргэдийн талаас илүү хувь нь 45-аас дээш хоногийн дараа өвчилсөн байна. Тухайлбал, 11-19 настай хүүхдүүдийн 22.7 хувь нь дархлаажуулалтын бүрэн тунд хамрагдсанаас хойш 14 хоногийн

дотор, 18.2 хувь нь 15-30 хоногт, 22.1 хувь нь 31-45 хоногт халдвар авсан бол 80-84 настай иргэдийн 15.8 хувь нь 14 хоногийн дотор, 23.9 хувь нь 15-30 хоногт, 24.6 хувь нь 31-45 хоногийн дотор халдвар авсан байна.


Тэгвэл 55-64 настай иргэдийн 54 хувь нь дархлаажуулалтын бүрэн тунд хамрагдсанаас хойш 45-аас дээш хоногийн дараа халдвар авсан байна (Зураг 5).

Зураг 5. КОВИД-19-ийн эсрэг вакцины бүрэн тунд хамрагдаад өвчилсөн иргэд, насны бүлэг, хамрагдсанаас хойш өвчилсөн хоног, дүнд эзлэх хувиар



Эх үүсвэр: Халдварт өвчин судлалын үндэсний төв, Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв

Зураг 6. КОВИД-19-ийн халдвараар нас барсан хүн, вакцинд хамрагдсан байдал, дүнд эзлэх хувиар



КОВИД-19-ийн халдвараар нас барагчдын дийлэнх буюу 52.5 хувь нь вакцинд хамрагдаагүй, 24.2 хувь нь бүрэн тунд, 23.3 хувь нь I дүгээр тунд хамрагдсан байжээ (Зураг 6).

Эх үүсвэр: Халдварт өвчин судлалын үндэсний төв, Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв